

## ТАНИЛЦУУЛГА

“Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”-ийн төслийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан ба 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон.

Тус хуулийн 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсэгт “Засгийн газар улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг тогтоож, улсын байцаагчийн дүрмийг батална” гэж заасан тул худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн үйл ажиллагааг зохицуулж, улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг тогтоох зорилго бүхий дүрмийн төсөл боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”-ийн дагуу төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн чиг үүргийг тус яамны худалдан авах ажиллагааны бодлогын асуудал хариуцсан нэгжийн албан хаагчид хавсран хэрэгжүүлдэг.

Эдгээр албан хаагчид нь тус хуульд зааснаар тендер шалгаруулалттай холбогдох гомдлыг хянан шийдвэрлэх, худалдан авах ажиллагааны бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын төслийг боловсруулах, судалгааны ажил хийх, захиалагч болон иргэд, олон нийтэд сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна Засгийн газраас баталсан “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх журам”-ын дагуу 217 тендерт оролцогчтой холбогдох хяналт шалгалтыг хийсний үр дүнд 130 хуулийн этгээдийн тендерт оролцох эрхийг хязгаарлах саналыг гаргаж ажилласан байна.

Мөн худалдан авах ажиллагааны улсын байцаагч нар нь тусгай мэдлэг, мэргэшил шаардлагатай хяналт шалгалтын ажлын хэсгийн гишүүн, нээлттэй сонголлын шинжээчийн үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр гүйцэтгэж байна.

Худалдан авах ажиллагааны улсын байцаагч нар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.8 дахь заалтад заасан чиг үүргийн хүрээнд зөвлөмж, тайлбар гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, 2023 оны хувьд 81 эрүүгийн хэрэгт Авлигатай тэмцэх газрын хүсэлтээр зөвлөмж, тайлбар гаргаж ажилласан ба шаардлагатай асуудлаар тайлбар, мэдүүлэг өгч ажиллажээ.

Хуулийг шинэчлэн найруулсантай холбоотойгоор худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж, үйл ажиллагаагаа хараат бус, бие даан хэрэгжүүлэх баталгааг тогтоох ба Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, 2022 оны 88 дугаар тогтоолд өөрчлөлт оруулахаар тусгасан болно.

САНГИЙН ЯАМ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны .... дугаар сарын .... -ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар ....

### ДҮРЭМ БАТЛАХ, УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 56 дугаар зүйлийн 56.2, 56.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатад худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн эрхийг шинэчлэн олгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм, журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай” Засгийн газрын 2022 оны 88 дугаар тогтоолын “22.2, Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрмийн 3.1-д заасныг” гэснийг “22.2-т” гэж өөрчилж, тус тогтоолын 1 дэх заалтын “болон худалдан авах ажиллагааны” гэснийг хассугай.

5. Энэ тогтоолыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Сангийн сайд

Б.ЖАВХЛАН

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль (цаашид “хууль” гэх)-ийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт заасан худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулж, улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг тогтооход энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Улсын ерөнхий байцаагч хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-56.7-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### Хоёр. Улсын байцаагчийн үйл ажиллагааны зарчим

2.1. Улсын байцаагч нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зарчмаас гадна дараахь зарчмыг удирдлага болгон ажиллана:

2.1.1. бусдын нөлөөнд үл автах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.1.2. бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх;

2.1.3. асуудалд бодитой хандаж, шалгалтыг зөвхөн нотлох баримтад тулгуурлан хийх;

2.1.4. албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээллийг задруулахгүй байх, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх.

### Гурав. Улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

3.1. Улсын ерөнхий байцаагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газар, хэлтсийн дарга нарт улсын ахлах байцаагчийн эрхийг, төрийн албанд гурваас доошгүй жил ажилласан ахлах шинжээч, шинжээч, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэнд улсын байцаагчийн эрх олгож болно.

3.2. Улсын ерөнхий байцаагч дараахь тохиолдолд улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг түдгэлзүүлнэ:

3.2.1.гэмт хэрэгт холбогдуулан шалгаж байгаа үндэслэлээр эрх бүхий байгууллагаас хүсэлт ирүүлсэн;

3.2.2.Төрийн албаны тухай хуулийн 46.1-д заасны дагуу төрийн албанаас түр чөлөөлсөн.

3.3.Улсын ерөнхий байцаагч дараахь үндэслэлээр улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргана:

3.3.1.Төрийн албаны тухай хууль болон энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хуулиар олгосон эрхээ хэтрүүлсэн, улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг зөрчсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

3.3.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өөр байгууллагад ажил, албан тушаалд томилогдсон, эсхүл тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөн.

3.4. Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгосон бол түүний хэрэглэж байсан үнэмлэх, тэмдгийг эргүүлэн авна.

### **Дөрөв. Улсын байцаагчийн эрх, үүрэг**

4.1. Улсын байцаагч нь улсын ахлах байцаагчид, улсын ахлах байцаагч нь улсын ерөнхий байцаагчид тус тус ажлаа хариуцан тайлагнана.

4.2. Улсын байцаагч нь хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах эрхийг эдэлнэ:

4.2.1. захиалагчийг хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.10 дахь заалтад заасан үүргийн хүрээнд бүрэн мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг шаардах;

4.2.2. хяналт шалгалтын ажилд саад учруулсан, эсэргүүцсэн этгээдэд өөрийн эрх хэмжээний хүрээнд болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж, зохих арга хэмжээ авах;

4.2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөх, гүйцэтгэлийг хангуулах, ажилтан, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр даалгах;

4.2.4. улсын ерөнхий байцаагчийн (бичгээр) зөвшөөрснөөр худалдан авах ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоох;

4.2.5. хяналт шалгалтын ажилд холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах саналаа улсын ерөнхий байцаагчид тавьж шийдвэрлүүлэх;

4.2.6. хяналт шалгалт хийсэн өөрийн ажилтай холбогдох хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд дангаар болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хамт оролцох, тайлбар өгөх;

4.2.7. хяналт шалгалтын явцад илэрсэн нөхцөл байдал гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол энэ тухай улсын ерөнхий байцаагчид танилцуулж, шалгалтын акт, холбогдох бичиг баримтыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

4.2.8. өөрийн илрүүлсэн нөхцөл байдал, эсхүл төрийн байгууллага, албан тушаалтнаас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичиг, иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажиллагаа явуулах санал гаргах;

4.2.9. энэ дүрмийн 4.2.7-д заасан санал гаргах үндэслэлтэй эсэхийг тогтоохтой холбоотой баримт материал цуглуулах ажиллагаа явуулах;

4.2.10. өргөдөл, мэдээлэлд дурдсан болон хяналт шалгалт хийж буй асуудлаар худалдан авах ажиллагааны цахим систем, цахим санхүүгийн тайлангийн систем болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрх авах, эдгээр мэдээллийн системээс баримт бичиг

4.3. Улсын ахлах байцаагч нь энэ дүрмийн 4.2-т зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1. улсын байцаагчийн үйл ажиллагаанд хуульд заасны дагуу хяналт тавих;

4.3.2. улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай саналыг улсын ерөнхий байцаагчид гаргах.

4.4. Улсын ерөнхий байцаагч нь энэ дүрмийн 4.3-т зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1. улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн үйл ажиллагаанд хуульд заасны дагуу хяналт тавих;

4.4.2. холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шийдвэр гаргах;

4.4.3. улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдон гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй улсын байцаагчийн албан шаардлага, дүгнэлт, актыг хүчингүй болгох;

4.4.4. улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

4.4.5. улсын байцаагчийн үндэслэл бүхий санал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичиг, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийлгэхээр улсын байцаагчийг томилон ажиллуулах;

4.4.6. хяналт шалгалтын удирдамж батлах, хугацаа сунгах.

4.4.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

4.5. Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь акт, дүгнэлт, албан шаардлагын хэвлэмэл хуудас, үнэмлэх, тэмдэг хэрэглэнэ.

### **Тав. Хяналт шалгалт хийх журам**

5.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.3-т зааснаас бусад тохиолдолд улсын байцаагч нь хяналт шалгалтыг зөвхөн улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хийнэ.

5.2. Хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа 30 хоногоос хэтрэхгүй, шаардлагатай тохиолдолд улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр энэ хугацааг 30 хоногоор сунгаж болно.

5.3. Улсын байцаагч хяналт шалгалтын дагуу сонсох ажиллагаа явуулахаар товлосон хугацааг заасан мэдэгдлийг шалгуулагчийн шуудангийн хаягаар хүргүүлнэ. Шалгуулагчийн тендерт ирүүлсэн, эсхүл гэрээнд заасан хаягийг албан ёсны хаяг гэж үзнэ.

5.4. Хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1 дэх заалтад заасан нөхцөлтэй холбоотой хяналт шалгалтад шалгуулагч нь өөрийн тендерт ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг нотлох үүргийг хүлээх ба зохих баримт бичгээр нотолж чадахгүй тохиолдолд тус заалтад заасан нөхцөл үүссэн гэж дүгнэнэ.

5.5. Хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.3 дахь заалтад заасан нөхцөлтэй холбоотой хяналт шалгалтад захиалагчаас ирүүлэх баримт бичигт дараахийг шаардана:

5.5.1. захиалагч, эсхүл гүйцэтгэгч гэрээг цуцалсан, гэрээнээс татгалзсан нь гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгээгүйтэй холбоотой болохыг нотлох баримт, гэрээ цуцалсан, татгалзсантай холбоотой мэдэгдлүүд;

5.5.2. гүйцэтгэгч гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас захиалагч хохирол барагдуулахыг шаардсан тохиолдол нь гэрээний үүрэг гүйцэтгэж байх хугацаанд, эсхүл үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсны дараа үүссэн эсэх нотлох баримт;

5.6. Хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан хяналт шалгалтын явцад тухайн нөхцөл үүсэх үед оролцогчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлж, дүгнэлтэд тусгана.

5.7. Улсын байцаагч хяналт шалгалтын дүнг тухайн шалгалт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор дээд шатны улсын байцаагчид танилцуулна.

5.8. Улсын байцаагч хяналт шалгалтын талаархи дүгнэлтийг 2 хувь үйлдэн гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулах бөгөөд дүгнэлтийг шалгуулсан этгээдэд танилцуулж гарын үсэг зуруулан, нэг хувийг түүнд өгнө. Шалгуулсан этгээд дүгнэлтэд гарын үсэг зурахаас татгалзсан нь хяналт шалгалтын талаархи дүгнэлтийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

5.9. Худалдан авах ажиллагааны улсын байцаагч гаргасан дүгнэлт, саналд гарын үсэг зурж, тэмдэг дарна.

### **Зургаа. Улсын байцаагчийн үйл ажиллагаа явуулах баталгаа**

6.1. Улсын байцаагч үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор Төрийн албаны тухай хуульд заасан баталгаанаас гадна дараах баталгаагаар хангагдана.

6.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан, захиалагч байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан, сургалт зохион байгуулсан, хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр тодорхой асуудалд зөвлөмж өгсөн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр онц чухал ач холбогдол бүхий хяналт шалгалт, сонсголын ажлын хэсэгт орж ажилласан нөхцөлийг үндэслэн үр дүнгийн шагнал олгож болно.

6.3. Улсын байцаагчийн үр дүнгийн шагналыг улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр сар бүр олгож болох бөгөөд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.

6.4. Улсын байцаагчийн үр дүнгийн шагналд шаардах хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

6.5. Улсын байцаагчийн ажлын үр дүнг тооцох, шагнал олгох шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг улсын ерөнхий байцаагч батална.

#### **Долоо. Бусад зүйл**

7.1. Хуулийн 56 дугаар зүйлийн 56.10-т зааснаар гомдол гаргах этгээд нь тухайн дүгнэлттэй холбоотойгоор гомдол гаргах этгээд нь улсын байцаагчийн шийдвэртэй холбоотойгоор Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-т заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн холбогдох этгээд байна.

7.2. Улсын байцаагч нь хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.